



“УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ/2018/49/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я. Самбууням
Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Аудитор Н. Нямдаваа
Утас: 260512 Цахим хаяг: naymdavaan@audit.gov.mn

“Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн гэрээ ажлын партнер Б.Осоргарав
Утас: 976-11-70110744 Цахим хаяг: info@mn.gt.com

Чанарын хяналтын партнер Н.Эрдэнэцог
Утас: 976-11-70110744 Цахим хаяг: erdenetsog.n@mn.gt.com

Аудитын менежер Б.Дэлгэрмаа
Утас: 976-11-70110744 Цахим хаяг: delgermaa.b@mn.gt.com

Ахлах аудитор Л.Болорцэцэг
Утас: 976-11-70110744 Цахим хаяг: bolortsetseg.l@mn.gt.com

Аудитор Ш.Оюунчимэг
Цахим хаяг: oyunchimeg.sh@mn.gt.com

Аудиторын туслах Т.Саранзаяа
Цахим хаяг: saranzaya.t@mn.gt.com

Улаанбаатар хот



АГУУЛГА

1.	Аудитын гэрчилгээ.....	2
2.	Аудитын тайлан	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Компанийн зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.4.	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим үр дүн	6
2.5.	Дотоод хяналт.....	7
2.6.	Бизнес төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	8
2.7.	Шилэн дансны мэдээлэл.....	8
2.8.	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	9
2.9.	Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар	9
2.10.	Аудитын явцад илрүүлсэн алдаа зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл..	10
2.11.	Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар.....	12
2.12.	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	12
2.13.	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	13
2.14.	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	13
2.15.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
2.16.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	14
2.17.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	14
3.	Менежментийн захидал	15
3.1.	Найдваргүй авлагын нөөцийн бүртгэлийн талаар.....	16
3.2.	Гэрээт ажлын гэрээний үүргийн биелэлт түүнд тавих хяналтын талаар..	17
3.3.	Жилийн үр дүнгийн шагналт цалингийн хэтрэлт түүний НББ-ийн хөтлөлтийн талаар.....	18
3.4.	Урьдчилж орсон орлого, нягтлан бодох бүртгэлийн алдааны талаар	19
3.5.	Авлагын тулган баталгаажилтын талаар.....	20
3.6.	Урьдчилж төлсөн зардлын талаар	21
3.7.	Анхан шатны баримт бүрдэлтийн талаар.....	22
3.8.	Дуусаагүй барилга дансны ангилал, бүртгэлийн талаар.....	23
3.9.	Өр төлбөрийн үлдэгдлийн тулган баталгаажилтын талаар.....	24
4.	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	25
4.1.	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	25
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан (үргэлжлэл).....	26
4.2.	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	27
4.3.	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	28
4.4.	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	30



1. Аудитын гэрчилгээ

“УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д. БАЯРСАЙХАН ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл


Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.



Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудитын тайланг гүйцэтгэх захирал Д. Баярсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, орлого үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшин, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд урьдчилж орсон орлого, дуусаагүй барилга дансны бүртгэлийн алдаа, гэрээний үүргийн биелэлтийг хангах, худалдан авсан бараа ажил үйлчилгээний үргүй зардал гаргахгүй байх, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.


2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаарын зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, “Төсвийн тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийв.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай, Эрчим хүчний тухай, Хөдөлмөрийн тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан заавар, журам нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлага, санхүүгийн тайлангаа СТОУС түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын хөдөлгөөн



журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлэн материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс 3 дугаар сарын 12-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлагад танилцуулахаар төлөвлөн “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн ахлах аудитор Л. Болорцэцэг, аудитор Ш. Оюунчимэг, аудиторын туслах Т.Саранзаяа нар гүйцэтгэж хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Аудитаар “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 27-ны өдөр “Улаанбаатар аудит корпораци” ХХК-д ирүүлсэн байна.

2.3. Компанийн зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин


“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Эрчим хүчний тухай, Компанийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Хөдөлмөрийн тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай болон бусад холбогдох хуулиуд СТОУС, Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн эрхэм зорилго нь “чадварлаг ажилтнуудаар чанартай үйлчилгээг хэрэглэгчдэдээ хүргэж, цахилгаан эрчим хүчийг найдвартай түгээгч, аюулгүй ажиллагааг хангасан салбартаа тэргүүлэгч компани болоход оршино” гэж тодорхойлжээ.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь Улаанбаатар хотын найман дүүрэг, Төв аймгийн 16 сумын нутаг дэвсгэрийн 307 мянга гаруй хэрэглэгч буюу Монгол Улсын нийт хүн амын 50 шахам хувийг цахилгаан эрчим хүчээр хангах үйл ажиллагаа эрхэлдэгээрээ эрчим хүчний дотоодын зах зээлд томоохон байр суурийг эзэлдэг байна. /ТАБ-СТА-А-1 маягтад дэлгэрэнгүй тусгасан болно/

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог”, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-д “Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ өөрөө бие даан борлуулдаг” гэсэн хуулийн заалтад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг.

“Компанийн тухай” хууль, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар тогтоол гаргаж компанийн тухайн оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин,



хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталдаг байна. Үүний дагуу тухайн оны бизнес төлөвлөгөөг баталж, биелэлтийн явцад хяналт тавьж ажиллахыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгодог байна.

Компанийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

2.4. Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуураа болголоо.

Аудитаар “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайлан бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын горим, сорил 3-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг "Интер Актив Ай Би Ай" ХХК-ийн “Диамонд-5” санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн материаллаг биш зөрчилтэй зарим асуудлыг энэ тайлангийн 2.10 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв

Тухайн компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мэргэжлийн байгууллагаар боловсруулж мөрдөн ажиллаж байна.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/



2.5. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гаргахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлт болон аудитын гүйцэтгэлийн ажлын үед дахин хянаж үзээд хэвийн байна гэж үзлээ.


Тайлант үед тус компанийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотой Дотоод аудитын хэлтэс шинээр байгуулагдсан ба 2016 оны 11 дүгээр сараас эхлэн хэлтсийн дарга-1, дотоод аудитын нягтлан бодогч-2, нийт 3 орон тоотой ажиллаж байна. Тус хэлтсийн дотоод аудитор, нягтлан бодогчид компанийн Гүйцэтгэх захирлын 2013 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/75 дугаар тушаалаар батлагдсан "Санхүүгийн дотоод аудитын журам"-ын дагуу 2017 онд санхүүгийн чиглэлээр 20 хяналт шалгалт хийхээс 15 нэгж, 5 хэлтэс, албаны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, шалгалтаар 330 асуудал илэрүүлж, цаашид анхаарч ажиллах талаар 290 асуудал дэвшүүлж 136.4 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн байна. Тухайн нэгжийн эдийн засаг, санхүүгийн үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийж илэрсэн зөрчил дутагдал, цаашид ажиллах зөвлөмжийг өгч, алдаа зөрчлийг арилгуулах арга хэмжээ авсан байна. Гүйцэтгэх захирлын удирдамжийн дагуу 38 удаа гэнэтийн хяналт шалгалт болон дүгнэлтүүдийг гаргаж, 11 албан тушаалтанд арга хэмжээ авч, 2 албан даалгавар хүргүүлсэн талаар дотоод аудитын хэлтсийн ажлын тайландаа тусгасан байна.

Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар компанийн Захирлын зөвлөлийн хурлаар оруулж, хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж холбогдох арга хэмжээг авч, уг шийдвэрт үндэслэн шалгалтад хамрагдсан нэгжүүдэд албан даалгавар, зөвлөмж өгч ажилладаг байна. Мөн нийтлэг гарсан алдаа дутагдлаар сургалт явуулдаг байна.

Компанийн Мэдээлэл технологийн хэлтсийн IT инженерүүд байгууллагын зорилго, зорилтуудыг хангахад ямар эрсдэлүүд гарч болохыг тодорхойлох, үнэлэх, санхүүгийн үйл ажиллагаанд учирч буй, цаашид учирч болзошгүй эрсдэлүүдийг үйл ажиллагааны бүх түвшинд тодорхойлон үнэлж, холбогдох арга хэмжээг цаг алдалгүй авахад зориулагдсан "Эрсдэлийн програм"-ыг зохиосон байна. Уг программыг 2015 оны 5 дугаар сараас туршиж, 8 дугаар сараас ашиглаж эхэлсэн байна.

Эрсдэлийн програмыг компанийн хэмжээний бүх бүртгэл санхүүгийн ажилтнууд ашиглах ба "Санхүүгийн үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ хийх журам"-ыг мөрдөж ажиллана.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 6 дугаар сарын 08-ний өдрийн 2016/16 тоот "Аудитын хороог шинэчлэн батлах тухай" тогтоолын дагуу Дотоод аудитын хороог дарга, 2 гишүүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсан ба тус компанийн дотоод хяналтын нягтлан бодогч нартай байнга холбоотой ажиллаж, ажилтай нь танилцаж үүрэг даалгавар өгдөг байна.



Аудитын хороо нь жил бүр гүйцэтгэсэн ажлын тайлангаа бэлтгэж, төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын тайланд нэгтгүүлдэг байна.

Аудитын хороо нь 2017 онд дараахь ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна:

- 2016-2017 онд Аудитын хорооны гүйцэтгэх ажлын төлөвлөгөө батлан түүний дагуу ажиллаж байна.
- Компанийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт гаргасан. 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт хийсэн байна
- Хараат бус Аудитын 2016 оны санхүүгийн тайлангийн дүгнэлт, зөвлөмжтэй танилцах, зөвшилцөх ажил хийсэн.
- Компанийн 2017 оны 1,2,3 дугаар улирлын санхүүгийн тайлантай танилцаж зөвлөгөө өгч ажилласан.
- Хараат бус аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар гүйцэтгэх удирдлагад зөвлөмж өгсөн.
- 2016, 2017 онуудын Зорилтот түвшиний үзүүлэлтүүдтэй нягтлан танилцаж тодорхой санал, зөвлөмж өгсөн.
- Компанийн дотоод хяналтын албаны ажилтай танилцаж, санал хүсэлтийг сонсож, зөвлөгөө өгсөн.

2.6. Бизнес төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Компани нь 2017 оны бизнес төлөвлөгөөгөө Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 04 сарын 18-ны өдрийн 10 тоот тогтоолоор батлуулан ажилласан байна.

Компанийн 2017 оны бизнес төлөвлөгөөгөөр 298,875.1 сая төгрөгийн орлоготой, 298,574.8 сая төгрөгийн зардалтай ажиллахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 362,331.1 сая төгрөгийн орлого олж, 358,783.2 сая төгрөгийн зардал гаргаж, 3,547.8 сая төгрөгийн ашигтай ажилласан.


Зорилтот түвшинөөс орлогыг 63,456.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэнтэй холбоотойгоор 60,208.4 сая төгрөгөөр зардлыг хэтрүүлсэн байна.

2.7. Шилэн дансны мэдээлэл

Сангийн яамны цахим хуудсанд ТӨХК-ийн статусын дагуу тус компанийн шилэн дансны ажлын хэсэг нийт 7 төрлийн мэдээллийг сар, улирал, жилээр нь цаг хугацаанд нь байршуулан ажилласан. Компани нь өөрийн вэб хуудсан дахь шилэн дансны мэдээлэлд тайлант жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний 267 нэр төрлийн нийт 14,886.8 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг оруулсан. Үүнээс нээлттэй тендер шалгаруулалтаар 10,299.8 сая төгрөг, харьцуулалтаар 4,158.3 сая төгрөг, шууд худалдан авалтаар 428.7 сая төгрөгийн худалдан авалтыг хийхээр мэдээлсэн байна.

Хуулийн хэрэгжилтэнд компанийн худалдан авах ажиллагааны хэлтсийн дотоод аудит, Эрчим хүчний яам тогтмол хяналт тавьдаг байна.

Эрчим хүчний яамны Дотоод аудитын хэлтсээс Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29-р тогтоолоор батлагдсан журмын дагуу шилэн дансыг хөтөлж, холбогдох 7 төрлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж байгаа эсэх талаар шалгалт хийж, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд зөрчилгүй үнэлгээ өгсөн байна.



2.8. Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 11 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 7 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. /ТАБСТА-В-3-1-9/

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.10-д хураагуйлан тэмдэглэв.

2.9. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, урьдчилж төлсөн зардал/тооцоо, өглөг, үйл ажиллагааны орлого, өмч, хөрөнгийн дахин үнэлгээ, цалин, сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тайлант хугацаанд Компани нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж ашиглалтанд орсон 17,781.6 сая төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө, нийслэлийн хөрөнгө оруулалтаар бий болсон 18.1 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө, албан байгууллага болон иргэдээс 7,177.9 сая төгрөгийн балансын үнэтэй 166.1 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан. Түүнчлэн “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 29.8 сая төгрөгийн балансын үнэ, 14.7 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үндсэн хөрөнгийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт балансаас балансад шилжүүлэн өгсөн байна.

Компани нь 2017 онд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт орсон өөрчлөлтийн дагуу насжилт өндөртэй, хуучирч хоцрогдсон, ашиглалт багатай бараа материалд 5 жилээс дээш насжилттай бараа материалд 100 хувь буюу 1,235.5 сая төгрөг, 3-4 жилийн насжилттай бараа материалд 3 хувь буюу 30.8 сая төгрөг нийт 1,266.4 сая төгрөгийн бараа материалын хасагдуулга байгуулж, цэвэр боломжит үнэ цэнээр тайлагнаж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн А-5/1941 дугаар албан бичгээр, Гүйцэтгэх захирлын 2017 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн А/144 тоот тушаалаар 634.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.



2.10. Аудитын явцад илрүүлсэн алдаа зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитын явцад нийт 4,250.8 төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд:

2.10.1. Гэрээт ажлын гэрээний үүргийн биелэлт түүнд тавих хяналтын талаар

2009 оноос 2016 оны хооронд 12 компанитай байгуулсан гэрээт ажлын гүйцэтгэл дутуу, ажил хүлээлцсэн акт үйлдээгүй, гэрээний хугацаа дуусан боловч гэрээт ажил нь дуусаагүй, эзэн холбогдогч нь тодорхойгүй нийт **2,520.5 сая** төгрөгийг “Дуусаагүй барилга данс”-нд он дамжин бүртгэж, дансны буруу ангилалд илэрхийлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6-д “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний үйл ажиллагаанд хяналт тавих” заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Бараа ажил үйлчилгээг хүлээн авсан, ажлын гүйцэтгэл тус бүрээр гэрээнд заагдсан хугацааны дагуу биелэлтийг үе шатанд нь хяналт тавьж, ажил хүлээлцсэн актаар дүгнэж ажил үүргийн дагуу хариуцлага тооцож ажиллах талаар зөвлөмж өгөх.

2.10.2. Урьдчилж орсон орлого, нягтлан бодох бүртгэлийн алдааных талаар

Тус компани нь Эрдэс баялаг эрчим хүчний сайдын 2011 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 248 тоот тушаалыг үндэслэн хийгдэх Сүхбаатар дүүрэгт байрлалтай хуваарилах байгууламж РП-7-ийн хүчин чадлыг нэмэгдүүлж, өргөтгөх гэрээт ажлын урьдчилгаанд нийт 1,378.4 сая төгрөг авсанаас худалдан авсан гэх 482.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн аваагүй, холбогдох дансанд бүртгээгүй, 577,8 сая төгрөгийн кабелийн ажил хийгдэж үндсэн хөрөнгө дансанд бүртгэж авсан боловч, өнөөг хүртэл 1,378.4 сая төгрөгөөр урьдчилж орсон орлого дансанд дансны ангиллыг буруу бүртгэж нягтлан бодох бүртгэлийг алдаатай бүртгэж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; 10 дугаар зүйлийн 10.1.11-д “Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах”; 14.2.3-д “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6.-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Ажил гүйцэтгэлийн хяналт, ажил хүлээлцэх удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд шийдвэрлэж ажиллах, зөрүү дүнгээр акт, албан шаардлага өгөх.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2.10.3. Авлагын тулган баталгаажуулалтын талаар

Дэлхийн банкны төслийн хүрээнд "Тулга тайш" ХХК-иас 83.0 сая төгрөг, "Сэконс" ХХК-иас 98.5 сая төгрөг, "Эрчим хүчний барилга тресст" ХХК-иас 55.1 сая төгрөг, **нийт 236.6 сая төгрөгийн** авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар тулган баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Гүйцэтгэсэн ажил үйлчилгээний дагуу тухай бүр тооцоо нийлж тулган баталгаажуулах зөвлөмж өгөв.

2.10.4. Урьдчилж төлсөн зардлын талаар

“Булаат” ХХК-тай 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдөр Антисептикжүүлсэн гуалин материал худалдан авахаар байгуулсан ТС-10/2017-288 тоот гэрээний дагуу урьдчилгаанд 175.0 сая төгрөгийг олгосон боловч материалыг хүлээн аваагүй, гэрээний хугацаа дууссан өнөөг хүртэл урьдчилж төлсөн дансанд бүртгэж, мөнгөн хөрөнгийн эргэлтийг удаашруулж, үргүй зардал болох эрсдэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6.-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”- заалтуудыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь:


Ажил гүйцэтгэлийн хяналт, ажил хүлээлцэх удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд шийдвэрлэж ажиллах талаар албан шаардлага өгөх.

2.10.5. Анхан шатны баримт бүрдэлтийн талаар

"Эрчим электрик" ХХК-иас 621.5 сая төгрөгийн материал худалдан авахаар байгуулсан ТС-03/2016/17 тоот гэрээний хавсралт №01-н дагуу материал хүлээлцсэн акт үйлдсэн боловч 115.0 сая төгрөг (*Програм хангамж, SCADAмоног төхөөрөмж*)-н материалыг хүлээн авсан нь баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6.-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, мөн хуулийн 13 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Ажил гүйцэтгэлийн хяналт, ажил хүлээлцэх удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд шийдвэрлэж ажиллах талаар албан шаардлага өгөх.



2.10.6. Дуусаагүй барилга дансны ангилал, бүртгэлийн талаар

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-иуд нь хамтран ажилчдын 594 айлын орон сууцыг “Баярс констракшн” ХХК-иар бариулахаар 2012/335 тоот хамтран ажиллахаар байгуулсан гэрээний дагуу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь ажиллагсадын нийгмийн хангамжийн төсөвлөсөн зардлын гүйцэтгэлтэй холбогдон гарсан **нийт 403.7 сая** төгрөгийн зардлыг Дуусаагүй барилга дансанд хуримтлуулан бүртгэж байгаа ба гэрээний дагуу гадна инженерийн шугам сүлжээтэй холбоотой гарсан санхүүжилтийг хэрхэн бүртгэх нь тодорхойгүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6.-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Урьдчилж гарсан зардал дансанд бүртгэж, эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан үед холбогдох зардлын болон хөрөнгийн дансанд хааж бүртгэх зөвлөмж өгөв.

2.11. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Энэхүү аудитаар 4,250.8 сая төгрөгийн материаллаг бус залруулаагүй алдаа байна.


2.12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 214 дүгээр тогтоол, 2017 оны 2 дугаар сарын 22-ны 65 дугаар тогтоолоор Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхөд үзүүлэх цахилгааны тарифын хөнгөлөлтөд шаардагдах 3,500.0 сая төгрөгийг Байгаль орчин аялал жуулчлалын яамны 2017 оны төсөвт баталж өгсөн байна.

Энэхүү тогтоолын дагуу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь тайлант оны нийт 6 сарын хугацаанд давхардсан тоогоор 515257 хэрэглэгчийн 6,084.0 сая төгрөгийн шөнийн цахилгааны тарифыг хөнгөлсөн байна. Гэвч Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас 3,500.0 сая төгрөгийн санхүүжилтийг өгч, 2,584.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй бөгөөд тус компани авлагаар тайлагнасан. Энэхүү тооцоо нийлэх, авлага барагдуулах асуудлыг Байгаль орчин аялал жуулчлалын яаманд гүйцэтгэлийн мэдээ, албан тоотор хандсан боловч шийдвэрлүүлж чадаагүй нөхцөл байдал үүсээд байна.

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын хэрэглэгчдэд үйлчлэх төвийн нийт 877.6 сая төгрөгийн хуримтлагдсан өр төлбөр нь тооцоо нийлж баталгаажуулаагүй, маргаантай байгаа тул хууль хяналтын байгуулагаар шалгагдаж байна.

Тайлант онд төв компани болон салбар нэгжүүдийн хооронд үүссэн авлага 184,700.6 сая төгрөг, өглөг 238,549.4 сая төгрөгийг өмнөх үеийн хуримтлагдсан



ашиг дансанд, авлага 33,757.1 сая төгрөг, өглөг 2,562.4 сая төгрөгийг тайлант хугацааны ашиг алдагдал дансанд хааж бүртгэж байгаа нь өр, авалгатай хамааралгүй дансны үлдэгдлийг хааж санхүүгийн тайланг буруу илэрхийлэх, залилан, ашиглан шамшигдуулалт, ашиг сонирхол үүсэх эрсдэлтэй байна.

Дээрх асуудлууд нь шийдэгдэхгүй хугацаа алдаж байгааг холбогдох албан тушаалтнууд анхааралдаа авч үзэх нь зүйтэй байна.

2.13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Компанийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудит нь цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан дараах данс бүртгэлийг бүрэн шалгаж амжаагүй тул дараагийн тайлангийн жилд доорх асуудалд анхаарлаа хандуулна.

Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр тендерийн шалгаруулалтаар сонгогдон хийгдэж байгаа бараа, ажил үйлчилгээтэй холбоотой авлагын насжилт, ажлын гүйцэтгэл түүнд тавьж буй хяналт, гэрээний үүргийн биелэлт,
- Жил бүр найдваргүй болж байгаа насжилт өндөртэй авлага,
- Дуусаагүй барилга дансанд хуримтлагдаж буй зардлын үр дүн,
- Улсын төсөв, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хүлээн авч байгаа үндсэн хөрөнгө, аж ахуйн нэгжээс үнэ төлбөргүй авч буй үндсэн хөрөнгөнд өгсөн мэргэжлийн байгууллагын чанарын хяналт, дүгнэлт
- Насжилтийн хугацаа дууссан актлагдаж байгаа бараа материалын бодит байдал
- Үндсэн хөрөнгийн капиталжуулалтын насжилт, хуваарилагдах зардлууд анхаарал хандуулахаар байна.
- Компанийн нэгжүүдтэй үүссэн өр, авлагыг өмнөх хуримтлагдсан ашиг, тайлант ашигт хаагдсан гүйлгээнд анхаарал хандуулахаар байна.

2.14. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 9,230.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 4,401.7 сая төгрөгийн зөрчилд залруулга хийж, 3,160.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 850.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага. 240.0 сая төгрөгийг зөрчилд акт тогтоов.

Асуудлын бүртгэлийг баталгаажуулж, санхүүгийн тайлангийн аудитын тайланд хавсаргав.

2.15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөн байна. Өгөгдсөн 2 зөвлөмжийг бүрэн биелүүлсэн байна.



2.16. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 358,783.2 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 3,587.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.17. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ	Б.ОСОРГАРАВ	ОГНОО
ЧХХД, ПАРТНЕР	Н.ЭРДЭНЭЦОГ	ОГНОО:

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР	Л.БОЛОРЦЭЦЭГ	ОГНОО:
АУДИТОР	Ш.ОЮУНЧИМЭГ	ОГНОО
АУДИТОРЫН ТУСЛАХ	Т.САРАНЗАЯА	ОГНОО:



3. Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

<p>3.1. Найдваргүй авлагын нөөцийн бүртгэлийн талаар</p>	<p>Тэргүүлэх ач холбогдол №1</p>
---	---

ҮАГ-ын ажиглалт

Найдваргүй авлагын нөөц дансанд дараах зөрчил ажиглагдлаа. Үүнд:

- Баянзүрх дүүрэг-Хэрэглэгчдэд үйлчлэх төв болон Сүхбаатар дүүрэг-Хэрэглэгчдэд үйлчлэх төвд хамаарах найдваргүй авлагын нөөцийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан аргачлалын дагуу бууруулах тохируулгын бичилт хийхдээ тайлант үеийн хуримтлагдсан ашгийг 482.8 сая төгрөгөөр, өмнөх үеийн ашгийг 111.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нягтлан бодох бүртгэлийг алдаатай бүртгэсэн нь тайлант хугацааны орлого зардлыг буруу илэрхийлэхэд хүргэсэн байна.
- Хан-Уул-Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн тайлант онд байгуулсан **81.1 сая** төгрөгийн найдваргүй авлагын нөөцийг найдваргүй авлагын зардлаар бус тайлант үеийн хуримтлагдсан ашиг дансанд шууд бүртгэсэн нь тайлант хугацааны орлого зардлыг буруу илэрхийлэхэд хүргэсэн байна.

Энэ нь НББОУС 39-Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт стандартын 65 дугаар зүйлд заасны дагуу найдваргүй авлагын нөөц болон хасагдуулгыг үнэн зөв бүртгээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-д. *“нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”* заалтад нийцэхгүй байна

Эрсдэлүүд

Компанийн тасралтгүй үйл ажиллагаа доголдох, санхүүгийн мэдээлэл хэрэглэгчдэд буруу мэдээлэл хүргэх эрсдэлтэй байна.

ҮАГ-ын зөвлөмж

НББОУС 39-н 65 дугаар заалтын дагуу найдваргүй авлагын нөөц болон хасагдуулгыг үнэн зөв бүртгэх, нэгжүүдийн бүртгэл тооцооллыг тус бүр нь хянаж байх.

Аудитын явцад залруулсан.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгаж, энэ талаар бодлогын баримт бичигтээ тодорхой тусгах ажил зохион байгуулна.



<p>3.2. Гэрээт ажлын гэрээний үүргийн биелэлт түүнд тавих хяналтын талаар</p>	<p>Тэргүүлэх ач холбогдол №1</p>
--	---

ҮАГ-ын ажиглалт

2009 оноос 2016 оны хооронд 12 компанитай байгуулсан гэрээт ажлын гүйцэтгэл дутуу, ажил хүлээлцсэн акт үйлдээгүй, гэрээний хугацаа дуусан боловч гэрээт ажил нь дуусаагүй, эзэн холбогдогч нь тодорхойгүй нийт **2,520.5 сая** төгрөгийг “Дуусаагүй барилга данс”-нд он дамжин бүртгэж, дансны буруу ангилалд илэрхийлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6-д “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний үйл ажиллагаанд хяналт тавих” заалтыг зөрчсөн байна

Эрсдэлүүд

Үргүй зардал гарч, мөнгөн хөрөнгө шамшигдах, эзгүйдэх үр ашигт нөлөөлөх эрсдэлтэй

ҮАГ-ын зөвлөмж

Бараа ажил үйлчилгээг хүлээн авсан, ажлын гүйцэтгэл тус бүрээр гэрээнд заагдсан хугацааны дагуу биелэлтийг үе шатанд нь хяналт тавьж, ажил хүлээлцсэн актаар дүгнэж ажил үүргийн дагуу хариуцлага тооцож ажиллах талаар зөвлөмж өгөх

Хэрэгжилтийг 2018 оны 6 дугаар сарын 01-ний дотор албан тоотоор ирүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

Менежмент захидалд зөвлөмжөөр авч хариуцсан албадад нь хүргүүлэх нь зүйтэй байна.



<p>3.3. Жилийн үр дүнгийн шагналт цалингийн хэтрэлт түүний НББ-ийн хөтлөлтийн талаар</p>	<p>Тэргүүлэх ач холбогдол №1</p>
---	---

ҮАГ-ын ажиглалт

2016 онд хамаарах **3,726.1** сая төгрөгийн үр дүнгийн шагналт цалинг 2017 онд олгохдоо мөнгөн сууриар бүртгэж, 2017 оны зардалд хүлээн зөвшөөрсөн байна. Энэ нь Гүйцэтгэх захирлын тушаалыг зөрчсөн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.1, 6.1, “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, тус хуулийн 13 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт”-ыг тус тус зөрчсөн байна

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланг бодит бус илэрхийлэх,

ҮАГ-ын зөвлөмж

Батлагдсан төсөв төлөвлөгөөний дагуу зүй зохистой дүрэм журам, тушаалын дагуу ажиллах, нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөх.

Аудитын явцад залруулсан.

Үйлчлүүлэгчийн хариу

Жилийн үр дүнгийн шагналт цалин нь “Жилийн ажил үйлчилгээний үр дүнгээр шагналт цалин олгох тухай журам”-д заасан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу жилийн эцсийн балансын тоон үзүүлэлтэнд үндэслэгддэг буюу баланс тайлагнагдсаны дараа олгогддог тул Эрчим хүчний системийн хэмжээнд жилийн эцсээр олгож бүртгэдэг. Иймээс энэхүү асуудлыг системийн хэмжээнд болон төсөв төлөвлөгөө, зорилтот түвшиний үзүүлэлт баталдаг ТӨБЗГ, ЭХЗХ-ний эрх үүргийн хүрээнд шийдвэрлэгдэх асуудал



3.4. Урьдчилж орсон орлого, нягтлан бодох бүртгэлийн алдааны талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тус компани нь Эрдэс баялаг эрчим хүчний сайдын 2011 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 248 тоот тушаалыг үндэслэн хийгдэх Сүхбаатар дүүрэгт байрлалтай хуваарилах байгууламж РП-7-ийн хүчин чадлыг нэмэгдүүлж, өргөтгөх гэрээт ажлын урьдчилгаанд нийт 1,378.4 сая төгрөг авсанаас 560.0 сая төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авч холбогдох дансанд бүртгээгүй, 577,8 сая төгрөгийн кабелийн ажил хийгдэж үндсэн хөрөнгө дансанд бүртгэж авсан боловч, өнөөг хүртэл 1,378.4 сая төгрөгөөр урьдчилж орсон орлого дансанд дансны ангиллыг буруу бүртгэж нягтлан бодох бүртгэлийг алдаатай бүртгэж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; 10 дугаар зүйлийн 10.1.11-д “Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах”; 14.2.3-д “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6.-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалтуудыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Хөрөнгө үр ашиггүй зарцуулагдаж, үргүй зардал гаргах эрсдэлтэй


ҮАГ-ын зөвлөмж

Ажил гүйцэтгэлийн хяналт, ажил хүлээлцэх удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд шийдвэрлэж ажиллах талаар акт албан шаардлага өгөх.

Хэрэгжилтийг 2018 оны 6 дугаар сарын 01-ний дотор албан бичгээр ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Тус РП-7 хуваарилах байгууламж нь СБД-т байрлах Засгийн газрын ордон болон бусад газрын цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг сайжруулахаар зарлагдсан бөгөөд газрын маргааны улмаас уг ажил нь хийгдээгүй тул орлогыг нь УОО дансанд, шаардлагатай бараа материалыг нь Дуусаагүй барилга дансанд бүртгэсэн. Энэхүү асуудлаар төрийн аудитын байгууллага талууд ойлголцсон гэж үзэж байгаа тул хасуулах саналтай байна.



<p>3.5. Авлагын тулган баталгаажилтын талаар</p>	<p>Тэргүүлэх ач холбогдол №2</p>
---	---

ҮАГ-ын ажиглалт

Дэлхийн банкны төслийн хүрээнд "Тулга тайш" ХХК-иас 83.0 сая төгрөг, "Сэконс " ХХК-иас 98.5 сая төгрөг, "Эрчим хүчний барилга тресст" ХХК-иас 55.1 сая төгрөг, **нийт 236.6 сая төгрөгийн** авлагын үлдэгдлийг аудитаар тооцоо нийлсэн актаар тулган баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалтыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Хөрөнгө үр ашиггүй зарцуулагдаж, үргүй зардал гаргах эрсдэлтэй

ҮАГ-ын зөвлөмж

Гүйцэтгэсэн ажил үйлчилгээний дагуу тухай бүр тооцоо нийлж тулган баталгаажуулах зөвлөмж өгөв.

Хэрэгжилтийг 2018 оны 6 дугаар сарын 01-ний дотор албан бичгээр ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

